

**Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал
/2019 оны 3 дугаар сар/**


Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), $PM_{2.5}$, PM_{10} тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O_3) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багаж болон химийн аргаар тодорхойлж байна.

2019 оны хүйтний улирлын 3 дугаар сарын Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын дундаж агууламжийг 2018 оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM_{10} тоосонцор 29 мкг/м^3 -ээр буюу 23%-аар, $PM_{2.5}$ тоосонцор 6 мкг/м^3 -ээр буюу 11%-аар тус тус их, хүхэрлэг хий, азотын давхар исэл өөрчлөлтгүй байлаа.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м^3	
	Хүлцэх агууламж, мкг/м^3	2018 оны 3-р сар	2019 оны 3-р сар
PM_{10} тоосонцор	100	124	153↑
$PM_{2.5}$ тоосонцор	50	56	62↑
Хүхэрлэг хий, SO_2	50	26	26↔
Азотын давхар исэл, NO_2	50	37	37↔

Улаанбаатар хотын сүүлийн жилүүдийн хүйтний улирал дахь гол бохирдуулах бодис тус бүрийн сарын дундаж агууламжийг дараах хэсэгт харуулав.

PM10 тоосонцор




Зураг 1. Хүйтний улирлын PM_{10} тоосонцорын сарын дундаж агууламж, 2015-2019 он

Улаанбаатар хотын агаар дахь PM_{10} тоосонцорын 2019 оны 3 дугаар сарын дундаж агууламжийг 2018 оны мөн үетэй харьцуулахад 23%-иар их, Агаарын чанарын стандарт

дахь Хүлцэх агууламж /цаашид АЧС дахь ХА гэх/-тай харьцуулахад 1.5 дахин их байна (Зураг 1).


PM2.5 тоосонцор



Зураг 2. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2015-2019 он

Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын 2019 оны 3 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11%-иар их, АЧС дахь ХА-аас 1.2 дахин их байна (Зураг 2).


Хүхэрлэг хий (SO₂)



Зураг 3. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2015-2019 он

Агаар дахь хүхэрлэг хийн 2019 оны 3 дугаар сарын дундаж агууламж 2018 оны мөн үеийн түвшинд, АЧС дахь ХА-аас хэтрээгүй байна (Зураг 3).

Азотын давхар исэл (NO₂)



Зураг 4. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2015-2019 он

Агаар дахь азотын давхар ислийн 2019 оны 3 дугаар сарын дундаж агууламжийг 2018 оны үетэй харьцуулахад өөрчлөлтгүй, АЧС дахь ХА-аас хэтрээгүй байна (Зураг 4).

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР